



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Оргилдорж шүг ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/051/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 300
танай _____ -ны № _____ -т

ОРГИЛДОРЖ ШҮГ ОНӨААТҮГ-ЫН
ЭРХЛЭГЧ Г.УРАНТӨГС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Оргилдорж шүг ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 5,093.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 96.2 мянган төгрөгийн эмийн сангийн барилгыг данснаас хасаж, 11,355.0 мянган төгрөгийн газрыг шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626050432

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,309,671.27	468,520.40
1.1.6	Бараа материал	15,261,042.38	17,365,325.47
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	16,570,713.65	17,833,845.87
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,426,458.40	-
1.2.2	Биет бус хөрөнгө	1,056,000.00	792,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,482,458.40	792,000.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,053,172.05	18,625,845.87
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	6,130,292.30	12,930,825.49
2.1.1.3	Татварын өр	-	2,686,132.38
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,130,292.30	15,616,957.87
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,130,292.30	15,616,957.87
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	18,358,261.00	18,358,261.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,780,714.47	4,780,714.47
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(216,095.72)	(20,130,087.47)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	22,922,879.75	3,008,888.00
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	29,053,172.05	18,625,845.87

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	113,430,883.72	123,231,937.10
2	Борлуулалтын өртөг	99,847,141.35	94,266,330.78
3	Нийт ашиг	13,583,742.37	28,965,606.32
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	67,249,271.02	48,057,394.40
11	Санхүүгийн зардал	84,700.00	33,000.00
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(53,750,228.65)	(19,124,788.08)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(53,750,228.65)	(19,124,788.08)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	18,358,261.00	4,780,714.47	-	23,138,975.47
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(1,005,299.39)	(1,005,299.39)
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	18,358,261.00	4,780,714.47	(1,005,299.39)	22,133,676.08
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(19,124,788.08)	(19,124,788.08)
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	18,358,261.00	4,780,714.47	(20,130,087.47)	3,008,888.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	113,430,883.72	135,555,130.81
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	109,677,701.72	130,461,948.81
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	3,753,182.00	5,093,182.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	112,665,249.66	136,396,281.68
	Ажиллагчдад төлсөн	22,567,358.00	24,755,773.12
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,109,829.31	8,446,461.57
	Бараа материал худалдан авахад төлсөн	76,869,710.00	99,207,142.01
	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	4,143,652.35	1,652,910.23
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	974,700.00	2,333,994.75
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	765,634.06	(841,150.87)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
	Хүлээн авсан ноогдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,320,000.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,320,000.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4.1	Валютын ханшийн зөрүү	-	-
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(554,365.94)	(841,150.87)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,864,037.21	1,309,671.27
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,309,671.27	468,520.40

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт орлого	120,000.0	123,231.9	3,231.9
Борлуулалтын орлого	120,000.0	123,231.9	3,231.9
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	100,000.0	94,266.3	(5,733.7)
Нийт зардал	110,733.5	48,090.4	(62,643.1)
Бараа материалын зардал	77,585.6	22,213.1	(55,372.5)
Цалингийн зардал	32,923.4	24,755.8	(8,167.7)
Элэгдлийн зардал	224.5	1,121.5	896.9
Нийт ашиг	9,266.5	(19,124.8)	(27,464.7)
Орлогын татвар	926.5	-	(926.5)
Цэвэр ашиг	8,339.8	(19,124.8)	(27,464.7)
Нийт өр төлбөр	-	15,617.0	15,617.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад 12.6 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Тайлант хугацааны борлуулалтын орлогыг 11.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.
- Компьютер тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг 0.8 сая төгрөгөөр илүү тооцоолж, бүртгэсэн зэрэг алдаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 0.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 0.2 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1.5 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өр төлбөрийн үлдэгдэл нь бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлсэн актаас 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг гаргахын өмнө өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж, зөрүүтэй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч ажиллах;

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9.6 сая төгрөгийн 41 хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, өртгийг шинэчлэн тогтоогүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, өртгийг шинэчлэн тогтоож эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр бүртгэлд тусгаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант хугацааны борлуулалтын орлогыг 11,825.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	11,825.4	-	-	1	11,825.4	1	11,825.4	-	-	-	-
2	Компьютер тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг 822.5 мянган төгрөгөөр илүү тооцоолж, бүртгэсэн байна.	1	822.5	-	-	1	822.5	1	822.5	-	-	-	-
	Дүн	2	12,647.9	-	-	2	12,647.9	2	12,647.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Өр төлбөрийн үлдэгдэл нь бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлсэн актаас 264.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	264.2	-	-	-	-	1	264.2	-	-	-	-
2	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9,687.4 мянган төгрөгийн 41 хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, өртгийг шинэчлэн тогтоогүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	2	264.2	-	-	-	-	2	264.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт									
1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 170 мэдээллээс байгууллагын санхүүгийн тайлан, байгууллагын аудитын тайлан гэсэн нийт 2 мэдээллийг байршуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт									
2	Өмнөговь аймгийн Ханбогд сумын засаг даргаар батлуулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй 16,084.12 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	16,084.1	-	-	1	16,084.1	-	-
	Дүн	2	16,084.1	-	-	2	16,084.1	-	-